



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЙДЫН АЛБАН ДААЛГАВАР

2023 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Усны сан бүхий газрыг бохирдохоос
хамгаалах, хуулийн хэрэгжилтийг хангах
арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, Усны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3, 12 дугаар зүйлийн 12.1.4, 13 дугаар зүйлийн 13.1.6, 17 дугаар зүйлийн 17.1.3, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.3 дахь заалтуудыг үндэслэн усны нөөцийг бохирдож, хомстохоос хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор "Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн зааг, тэжээгдлийн мужийг тэмдэгжүүлж, хамгаалах, тохижуулах, бүсийн дэглэмийн хэрэгжилтийг хангах", өвөлжилтийн хүндрэл, өвчний улмаас хорогдсон малын сэг зэмийг устгах, уст цэг, усны эх үүсвэрийг хамгаалах, бохирдохоос сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх зорилгоор Бүх шатны Засаг дарга, Сав газрын захиргаадын дарга нарт ДААЛГАХ нь:

Нэг. Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга нарт:

- 1.1. Усны эх үүсвэрийг орон нутгийн хамгаалалтад авах шийдвэр гаргах, хамгаалалтын бүсийн заагийг тогтоох;
- 1.2. Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүс, ус хангамжийн эх үүсвэрийн тэжээгдлийн мужийн заагийг тогтоож, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулах;
- 1.3. Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн зааг, тэжээгдлийн мужийг тэмдэгжүүлж, хамгаалах, тохижуулах, бүсийн дэглэмийн хэрэгжилтийг хангах;
- 1.4. Аймаг, нийслэл, сум, дүүргийн харьяалах нутаг дэвсгэрт хорогдсон мал, амьтны сэг зэмийг устгах, мал эмнэлгийн халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулах;
- 1.5. Харьяалах нутаг дэвсгэрт усны сан бүхий газар, түүний хамгаалалтын бүс, түүний орчмын газрын хог хаягдлыг цэвэрлэх тухай нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах;
- 1.6. Албан даалгаврыг холбогдох байгууллага, ард иргэд, малчдад хүргэх, нөлөөллийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

Хоёр. Сав газрын захиргаадын дарга нарт:

- 2.1. Бүх шатны Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг мэргэжлийн зөвлөмжөөр хангах;
- 2.2. Усны нөөцийг бохирдож, хомстохоос хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор усны сан бүхий газар, түүний хамгаалалтын бүс, түүний орчмын газрын хог хаягдлыг цэвэрлэх чиглэлээр аймаг, нийслэл, сумын дүүргийн Засаг дарга нартай хамтран ажиллах;

152320023

2.3.Гол мөрний сав дахь цас, мөс хайлж, хаврын шар усны үер цөн түрэлттэй давхцан ус эргээсээ халих, голын эргийн татам усанд автах, өвөлжилт хүндэрсэн газруудын гуу жалганд хаягдсан мал, амьтны сэг зэм цасны усаар дамжин ус бохирдуулах болон өвчин эмгэг тараах аюултай тул холбогдох байгууллагатай хамтран зохих арга хэмжээг цаг алдалгүй авч цэвэрлэгээ устгал хийх, ард иргэд хаврын шар усны үер болон мөс цөмрөх аюулаас сэрэмжтэй байхыг онцгойлон анхааруулах арга хэмжээг авах.

Гурав. Албан даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах

3.1.Албан даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллах, мал, амьтны сэг зэм цасны усаар дамжин усны нөөцийг бохирдохоос сэргийлэх арга хэмжээ авч ажилласан тухай тайланг 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Байгалийн нөөцийн бодлого зохицуулалтын газарт ирүүлэхийг Аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Сав газрын захиргаадын дарга нарт үүрэг болгосугай.

3.2.Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүс, ус хангамжийн эх үүсвэрийн тэжээгдлийн мужийн заагийг тогтоож, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн батлуулсан тухай тайлан мэдээг 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн дотор Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Байгалийн нөөцийн бодлого зохицуулалтын газарт ирүүлэхийг Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

САЙД



Б.БАТ-ЭРДЭНЭ